



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

28.25 оны 02 сарын 17 өдөр

дугаар 8/80

Улаанбаатар хот

Г М.Номин-Эрдэнэд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.5.2, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Мягмарсүрэнгийн Номин-Эрдэнэ нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь Хяналт шалгалтын газрын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны илтгэх хуудас болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдож байх тул түүнд 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 10 хувиар бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.


2. Өдөр тутмын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч М.Номин-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төгс-Эрдэнэ)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын бүртгэгч М.Номин-Эрдэнэд тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У.БОЛДХҮҮ



142500539